



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/010/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх

Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Отгонбаяр

Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитын гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: B.Naranchimeg.POA@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**"СЭЛЭНГЭ ЭНЕРГО" ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Б.АЛТАНСҮХ ТАНАА**

2026.03.15 № СЭЭ-2026/010/НА-СНА-ОНӨТ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол "Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ... , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8. дахь "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээр 1,136,539.8 мянган төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө бүрэн санхүүжүүлэн ажиллаж чадаагүй;

- Байгууллагын төсвөөр тэмцээн уралдаан санхүүжүүлсэн 8,178.0 мянган төгрөг,

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь ТӨБЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 9-ны өдрийн 464 дүгээр тогтоолын дагуу ЭХЯ-ны Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1,446,365.4 мянган төгрөгөөр дулааны станцын зуухны шинэчлэлтийн ажил, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 88,550.0 мянган төгрөгийн "DX60" гинжит экскаватор тээврийн хэрэгсэл, аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 88,260.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэлийг балансаас балансад шилжүүлэн бүртгэсэн зэрэг нийт 1,623,175.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд орлогыг 9,924,737.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 11,638,426.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,446,556.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11,583,095.9 мянган төгрөгийн зардал гаргаж, баталсан орлогын төлөвлөгөөг 521,818.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг 55,330.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2025 оны 1 сарын 1	2025 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,110,125.24	8,925,434.31
1.1.02	Дансны авлага	1,264,366,098.05	1,411,984,688.76
1.1.04	Бусад авлага	1,771,083.55	2,296,870.85
1.1.06	Бараа материал	1,085,393,064.27	909,808,140.03
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	2,063,621.92
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,353,640,371.11	2,335,078,755.87
1.2.01	Үндсэн хөрөнгө	14,018,484,650.47	15,112,300,392.97
1.2.02	Биет бус хөрөнгө	10,950,000.00	7,190,000.00
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	608,708,400.00	608,708,400.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,638,143,050.47	15,728,198,792.97
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,991,783,421.58</b>	<b>18,063,277,548.84</b>
2.1.1.01	Дансны өглөг	2,615,918,364.39	2,878,664,553.88
2.1.1.02	Цалингийн өглөг	198,674,403.23	202,915,442.00
2.1.1.03	Татварын өр	3,652,542,824.89	4,275,169,480.63
2.1.1.04	НДШ - ийн өглөг	2,597,796,193.18	2,301,282,202.04
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,064,931,785.69	9,658,031,678.55
2.1.2.01	Урт хугацаат зээл	39,699,662.53	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	39,699,662.53	0.00
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>9,104,631,448.22</b>	<b>9,658,031,678.55</b>
2.3.01	Өмч: - төрийн	12,575,644,758.87	14,198,820,204.87
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,736,940,966.15	8,736,940,966.15
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-13,425,433,751.66	-14,530,515,300.73
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-1,136,539,862.83
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-13,425,433,751.66	-13,393,975,437.90
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,887,151,973.36	8,405,245,870.29
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,991,783,421.58</b>	<b>18,063,277,548.84</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Бапансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	7,359,368,758.06	10,018,659,695.58
02	Борлуулалтын өртөг	9,694,416,212.54	10,387,911,955.10
03	Нийт ашиг( алдагдал)	-2,335,047,454.48	-369,252,259.52
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	249,948.16	2,878,157.68
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	41,800,000.02	35,596,818.20
08	Бусад орлого	2,706,042,998.29	389,421,369.67
08.1	Орлогын дүн	2,748,092,946.47	427,896,345.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	845,825,675.81	1,183,940,203.77
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	845,825,675.81	1,183,940,203.77
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	-11,243,745.09
17.1	Олз, гарзын дүн	0.00	-11,243,745.09
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-432,780,183.82	-1,136,539,862.83
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-432,780,183.82	-1,136,539,862.83
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-432,780,183.82	-1,136,539,862.83

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	12,575,644,758.87	8,736,940,966.15	-13,425,433,751.66	7,887,151,973.36
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	31,458,313.76	31,458,313.76
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-1,136,539,862.83	-1,136,539,862.83
14	Өмчид гарсан өөрчлөлт	1,623,175,446.00	0.00	0.00	1,623,175,446.00
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	14,198,820,204.87	8,736,940,966.15	-14,530,515,300.73	8,405,245,870.29

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,734,053,404.18	10,816,925,427.94
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,753,091,096.25	10,372,540,750.94
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	44,780,000.00	34,150,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,900,000,000.00	400,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	36,182,307.93	10,234,677.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,566,121,717.76	10,694,185,014.02
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,628,459,181.52	3,019,478,611.07
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	274,342,418.68	1,112,230,250.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,931,290,946.35	3,253,013,001.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,020,209,316.67	1,326,925,806.79
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,366,604,613.30	1,724,048,382.79
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	44,723,146.40	10,736,887.67
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	285,018,359.39	244,682,274.70
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,197,300.00	1,220,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	10,276,435.45	1,849,800.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	167,931,686.42	122,740,413.92
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	249,948.16	32,983,157.68
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	30,000,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	249,948.16	2,878,157.68
2.1.8	Бусад	0.00	105,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,618,981.80	79,208,600.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,618,981.80	79,208,600.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-50,369,033.64	-46,225,442.32
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,564,781,123.12	1,182,997,820.72
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,564,781,123.12	1,182,997,820.72
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,686,819,283.02	1,252,697,483.25
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,686,819,283.02	1,252,697,483.25
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-122,038,159.90	-69,699,662.53
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-4,475,507.12	6,815,309.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,585,632.36	2,110,125.24
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,110,125.24	8,925,434.31

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	м/төг	9,881,307,782.00	10,018,659,695.58	137,351,913.58	101%
2	Бусад орлого	м/төг	43,430,200.00	64,259,981.91	20,829,781.91	148%
3	Улсын төсвийн татаас	м/төг	-	363,636,363.64	363,636,363.64	0%
2	Нийт орлого	м/төг	9,924,737,982.00	10,446,556,041.13	521,818,059.13	105%
3	Нийт зардал	м/төг	11,638,426,300.50	11,583,095,903.96	- 55,330,396.54	99.5%
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	207,000,000.00	206,040,920.61	959,079.39	99.5%

4	Татварын өмнөх ашиг	м/төг	1,731,688,318.50	1,136,539,862.83	575,148,455.67	66.4%
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	1,731,688,318.50	1,136,539,862.83	575,148,455.67	66.4%
6	Төсвийн төлбөр	м/төг	2,896,545,000	2,896,535,557.88	-9442.12	100%
	а/Орлогын татвар	м/төг				
	б/НӨАТ	м/төг	1,680,000,000	1,680,510,568.18	510,568.18	100%
	в/НДШ	м/төг	1,156,170,000	1,156,013,803	-156,197	100%
	г/ХАОАТ	м/төг	42,000,000	42,070,000	70,000	100%
	д/ҮХЭХАТ	м/төг	9,861,600.00	9,255,270.70	-606,329.30	94%
	е/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	313,400.00	327,336.00	13,936.00	104%
	ё/Бусад татвар	м/төг	8,200,000.00	8,358,580.00	158,580	102%
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	128.00	124.00	-4.00	96%
8	Нийт цалингийн сан	м/төг	3,579,539,080.00	3,570,483,032.66	9,056,047.34	104%
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	2,330,429.08	2,399,518.16	186,849.31	108%
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	0.86	0.90	0.04	105%
11	Хөрөнгө оруулалт	м/төг	939,265,866.00	1,623,175,446.00	683,909,580.00	173%
12	Нийт авлага	м/төг	1,266,137,181.60	1,414,281,559.61	148,144,378.01	112%
	Үүнээс: найдваргүй	м/төг				
13	Нийт өглөг	м/төг	9,104,631,448.22	9,658,031,678.55	553,400,230.33	106%
	Богино хугацаат өглөг	м/төг	9,104,631,448.22	9,658,031,678.55	553,400,230.33	106%
	Урт хугацаат өглөг	м/төг				

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 15,891.6 мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Дулааны төлбөрийн илүү төлөлт 15,891.6 мянган төгрөгийг дансны авлага бууруулж тайлагнасан;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд СТОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандарт болон "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,177,615.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчил арилгуулах 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,144,717.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,039,315.4 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ....." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Тус байгууллага нь захирлын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар тушаалаар ХАБЭА-н сарын аяны хаалтын үйл ажиллагааны хүрээнд нийт ажилтнуудын дунд зохион байгуулсан сургалт, тэмцээний зардалд 8,178.0 мянган төгрөгийн зардал гаргасан зөрчил илэрлээ

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8. дахь "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

**1.1 Илрүүлэлт:** НӨАТ төлөгч биш харилцагчаас авсан 32,897.8 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ыг салгаж бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** НӨАТ-ыг анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв бүртгэн тайлагнаж байх.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**  
**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агуй		Тоо	Дүн
Авлага бууруулж тайлагнасан	1	15,891.6			1	15,891.6	1	15,891.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>15,891.6</b>			<b>1</b>	<b>15,891.6</b>	<b>1</b>	<b>15,891.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
1. НӨАТ төлөгч биш харилцагчаас авсан худалдан авалтыг НӨАТ салган бүртгэсэн	1	32,897.8						1	32,897.8				
2. Жил бүр алдагдалтай ажиллаж хуримтлагдсан алдагдлын хэмжээ нэмэгдсэн	1	1,136,539.8			1	1,136,539.8							
3. Байгууллагын төсвөөр уралдаан тэмцээн зохион байгуулсан	1	8,178.0			1	8,178.0							
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,177,615.6</b>			<b>2</b>	<b>1,144,717.8</b>	<b>1</b>	<b>32,897.8</b>					

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	1	1				1		